# ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД - ЭХ ОРНЫ ЭРХЭМ БАЯЛАГ

## АЛСЫН ХАРАА

Эх хүүхдийн тусламж үйлчилгээгээр бүс нутагтаа тэргүүлэгч үндэсний чиглүүлэгч төв байна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Эх, хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эмнэлзүй-сургалт-эрдэм шинжилгээний нэгдэлд тулгуурлан, чанартай, хүртээмжтэйгээр үйлчлүүлэгчээ дээдэлсэн орчинд үзүүлэхийг эрхэмлэнэ.

## ҮНЭТ ЗҮЙЛС

- Мэргэшсэн, ес зүйтэй, ур чадвартай хүний нөөц
- Тэгш, хүртээмжтэй, чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээ
- Хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, техник, шинэ технологи, материаллаг нөөц
- Удирдлагын манлайлал, хариуцлага, ил тод байдал, эрхэм зорилго, зорилт
- Гэр бүлд суурилсан ээлтэй орчин, сэтгэл ханамжтай үйлчилгээ

## ЗОРИЛТ

- Эрдэм шинжилгээ, сургалт, практикийн гурвалсан нэгдлийг бэхжүүлэх
- Нотолгоонд суурилсан анагаах ухааны ололтыг хэргжүүлэн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх
- Хүүхдийн мэс заслын шилдэг техник, технологийг эмчилгээ, оношилгоонд өргөн нэвтрүүлэх
- Хүүхдэд эрхтэн шилжүүлэх тусламж үйлчилгээг хөгжүүлэх
- Хүүхдийн халдрын оношилгоо, эмчилгээний асуудлыг цогцоор шийдвэрлэх
- Далхийн жишгийг эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг хөжгүүлэх
- Ураг, нярайн эрт оношилгооны үндэсний хэмжээнийтөв болох
- Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний загвар төв болох
- Дэлхийн жишгийн цахим эмнэлгийг төлөвшүүлэх

## ЗАРЧИМ

- Үйлчлүүлэгч төвтэй, хүнлэг, энэрэнгүй, ил тод, нээлттэй, тэгш, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх
- Төрийн хуулийг чандлан сахиж, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг ханган, эмнэлгийн мэргэжилтний ес зүйн хэм хэмжээг мөрдөх
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг чандлах
- Хүний нөөцийг тасралтгүй сургах, хөгжүүлэх замаар эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, ес зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх
- Тайлан мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангаж, үйл ажиллагаандаа явцын, гүйцэтгэлийн хяналт, дүгнэлт хийж ажиллах
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн нөөцийг оновчтой бүрдүүлэх, зүй зохистой ашиглах
- Жилийн үйл ажиллагааг өртөг зардлаар төсөвлөх, санхүүжилтийг урьдчилан төсөвлөгдсөн үйл ажиллагаанд зориулах, өр, авлагагүй ажиллах
- Олон улсын эмчилгээ, үйлчилгээний шилдэг хандлага, зачмыг тасралтгүй нэвтрүүлэх